# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр Дугаар 86 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хүнсний нөөцийн салбарын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 7,236,000.00 (долоон сая хоёр зуун гучин зургаан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 1 (нэг) ширхэг автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Бадрал, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хүнсний нөөцийн салбарын дарга, ахмад Ц.Ертөнц нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

000013

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020
оны...03...дугаар сарын...10...ны өдрийн
...86...дугаар тогтоолын хавсралт

**Онцгой байдлын ерөнхий газрын Хүнсний нөөцийн салбарын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, актлаж данснаас хасах автомашины жагсаалт**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар | Ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын анхны үнэ (төгрөгөөр) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Үлдэгдэл өртөг (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хьюндай Соната-2 1006 УБЭ арал-179391 | 1994/2001 | 276000 | 7,236,000.00 | 7,236,000.00 | - |
| | Нийт дүн | | | 7,236,000.00 (долоон сая хоёр зуун гучин зургаан) | | |